



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,  
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

ТАВАНТОЛГОЙН ЦАХИЛГААН  
СТАНЦЫН ТӨСЛИЙН НЭГЖИЙН  
МЕНЕЖЕР Д.БАТБИЛЭГ ТАНАА

2017.02.20 № 3/271  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

### Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

\\10.10.10\Bichig\_Kherel\Yawsan\_Bichig\2017\0220SAG42Docx

070193



**УАГ**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## ТАВАН ТОЛГОЙН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙН НЭГЖИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:**

САГ-ын дарга  
Тэргүүлэх аудитор  
С.Энхзаяа  
Утас:261663  
Цахим хаяг:  
[enkhzayas@audit.gov.mn](mailto:enkhzayas@audit.gov.mn)

Аудитын менежер:  
Н.Золзаяа  
Утас:  
Цахим хаяг:  
[zolzayan@audit.gov.mn](mailto:zolzayan@audit.gov.mn)

Ахлах Аудитор: Н.Батсайхан  
Утас: 260512  
Цахим хаяг:  
[batsaikhann@audit.gov.mn](mailto:batsaikhann@audit.gov.mn)

ТАБ-ын хаяг: Үндэсний  
аудитын газар  
Байршил: Чингэлтэй дүүрэг  
ЗГ-н 4-р байр  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

“Б энд С Аудит” ХХК  
Захирал Д.Дашхорлоо  
Утас:70114810  
Цахим хаяг:  
[audit\\_bc@yahoo.com](mailto:audit_bc@yahoo.com)

### Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ  
Хавсралт 2: Менежментийн захидал  
Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан



## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт



### Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/45/СТА-ТӨҮГ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайланг УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 23-с 2017 оны 02 дугаар сарын 24-ныг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн “Б энд С аудит” ХХК-ийн 1 дүгээр багийн ахлах аудитор Д.Дашхорлоо, аудитор Д.Заяажаргал, аудиторын туслах П.Ундрах нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн 2016 оны санхүүгийн тайланг 2016 оны 12 дугаар сарын 19-ны 1/51 дугаар албан бичгийн дагуу 2017 оны 02 дугаар сарын 09-нд “Б энд С аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Б энд С аудит” ХХК аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 23-с 2017 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 23-нд “Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн удирдлагад гардуулна.

### Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Төрийн



албаны тухай”, Татварын ерөнхий, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Валютын тухай, Архивын тухай, Хөдөлмөрийн тухай, НДаатгалын тухай, “Шилэн дансны тухай хууль”-ууд болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөр зарим бүтээн байгуулалтын томоохон төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, Монгол Улсын төвийн бүсийн болон өмнийн говийн стратегийн орд газруудын эрчим хүчний хэрэгцээг хангах зорилгоор Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн “Чингис бонд”-оор санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх ажлын хүрээнд станц барих төслийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Төслийн нэгж нь цахилгаан станц барьж байгуулахад шаардагдах 1 тэрбум ам долларын хөрөнгийг олон улсын банк, санхүүгийн зах зээлээс босгох ажлыг зохион байгуулах үндсэн зорилготой бөгөөд олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын шаардлага хангасан төслийн баримт бичиг бэлтгэх, боломжит хөрөнгө оруулагчидтай хэлэлцээр хийх, шаардагдах бусад техникийн судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.16-д “Засгийн газрын шугамаар авч байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн нэгжийн дарга тухайн төслийн төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу “Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн дарга төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. “Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн 2016 оны төсвийг Эрчим хүчний ямаар батлуулж ажиллаагүй байна.

“Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.



## Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 11-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг НББОУС, УСНББОУС, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжинд нийцүүлэн боловсруулж мөрдөж ажиллаагүй байна.

“Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/ “Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох “Acolous” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

### Материаллаг байдлын түвшин

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт орлогын 1 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 5,235.9 мянган төгрөг гэж тооцов. Учир нь: Нийт орлого болон зардлаас материаллаг түвшинг тогтооход материаллаг түвшин өндөр гарч байгаа тул нийт орлогын 1 хувиар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

### Дотоод хяналт:

Аудитор санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хяналаа.

Ийнхүү хянахдаа “Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн хэрэгжүүлж байгаа дотоод хяналтыг санхүүгийн, хяналтын эрсдэл байвал зохих



горимтой харьцуулан шалгаж үзсэн. Үүний үр дүнд удирдлагаас зайлшгүй хэрэгжүүлэх дотоод хяналт ямар байгааг тогтоосон.

Аудитор байгууллагын удирдлагад бүртгэл санхүүгийн үйл ажиллагаа, тайлагнал, дотоод хяналтад илэрсэн сул талуудыг тухай бүрд нь мэдэгдэж зөвлөмж өгч ажилласан.

### Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

ЭХЯ-аар 2016 оны төсвийг батлуулаагүй, ТУХ-н 2016 оны 1 дүгээр сарын 4-ны 1 дугаар тоот албан бичгээр батлуулсан сар, улирлын хувиарын дагуу төслийн бэлтгэл ажлын зардлыг Хөгжлийн банкаар дамжуулан, үйл ажиллагааны урсгал зардлыг Голомт банкаар дамжуулан төсвийг зардлыг төрөл зүйлээр нь хувиарлан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

“Таван толгойн цахилгаан станц” төсөл хэрэгжүүлэх нэгжийн төсвийн захирагч нь 2016 онд төслийн нэгжийн үйл ажиллагааны зардалд Хөгжлийн банкнаас санхүүжилт аваагүй, үйл ажиллагааны урсгал зардалд 1,113,689.1 мянган төгрөг, төслийн бэлтгэл ажлын зардал урьдчилж гарсан зардал дансанд 7,236,2 мянган төгрөг, хөрөнгийн зардал 238,292.9 мянган төгрөг, бүртгэсэн нийт зардал 1,359,218.3 мянган төгрөг зарцуулж, 9,104,343,6 мянган төгрөг буюу 14,9 %-ийн биелэлттэй байна.

### Шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 394-р тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” тухай журам батлагдсаны дагуу төслийн нэгжийн байгууллагын вэб сайтад шилэн дансаа нээж 2016 онд 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээ байршуулсан байна.

### Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэхэд санхүүгийн тайланд нөлөөлөх хэмжээний материаллаг алдаа илэрсэнгүй.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Аудитын гүйцэтгэлээр төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж авч үзсэн эрсдэлүүдээс төсвийн хөрөнгийн орлого, зарлагатай холбоотой дараах зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг”, “хамааралтай байх”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдүүлийг хангахгүй байна.



### Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, цалин хөлс, тээвэр шатахуун, шуудан холбоо, хүүгийн зардал, гадаад дотоод томилолт, зочид төлөөлөгч хүлээн авах зардал, хангамжийн материал, татвар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа.

/ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, зардал, хөрөнгийн 86 хувийг эзэлж байна.

### Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад дараах алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Гадаад зочид төлөөлөгч хүлээн авах, хурлын зардал, бэлэг дурсгалын зүйл худалдан авах зэрэг үйл ажиллагаанд 1,331.9 мянган төгрөгийг дэмжин нотлох баримтгүйгээр зарцуулсан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 “анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” заалтыг мөрдөж ажиллаагүй байна

**Шийдвэрлэсэн:** Аудитийн хугацаанд баримтын бүрдлийг хангуулан зөрчлийг арилгуулав.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг НББОУС, УСНББОУС, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжинд нийцүүлэн боловсруулж мөрдөж ажиллаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.2-д “аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Менежментийн захидлаар холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

### Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Тайлант хугацаанд залруулагдаагүй алдаа байхгүй байна.



### Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Аудитын явцад анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

### Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

### Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1.338,1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг аудитын явцад залруулж ажилласан

### Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд хавсаргав.



# “ТАВАН ТОЛГОЙН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН НЭГЖИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Менежментийн захидал

### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1  
НББ бодлогын баримт бичгийн талаар .....  
хуудас-2



## Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Таван толгойн цахилгаан станц” төслийн нэгжийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**Асуудал 1: НББ бодлогын баримт бичгийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ Ажиглалт**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг НББОУС, УСНББОУС, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжинд нийцүүлэн боловсруулж мөрдөж ажиллаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.2-д “аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**ҮАГ Зөвлөмж**

Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

**Эрсдэлүүд**

Холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг зөрчсөн байх

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага санхүүгийн ажилтнуудад танилцуулж баталгаажуулсан болно.



Байгууллагын нэр: Таван толгойн цахилгаан станц, төслийн нэгж

Бэлтгэсэн огноо: 2017.01.30

Тайлант хугацаа: 2016.12.31

### АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>16,424,908,903.88</b>	<b>19,007,847,955.06</b>
Кассанд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	21,448,344.70	16,898,491.05
/валютаар/	14,542,394,595.80	17,746,184,464.01
Банкинд байгаа бэлэн мөнгө / төгрөгөөр/	1,861,065,963.38	1,244,765,000.00
<b>АВЛАГА</b>	<b>423,000.00</b>	<b>3,052,500.00</b>
Бусад авлага	423,000.00	3,052,500.00
<b>УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР</b>	<b>11,688,104,530.33</b>	<b>14,606,154,245.53</b>
Урьдчилж гарсан зардал	11,688,104,530.33	14,606,154,245.53
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>8,291,078.42</b>	<b>9,327,675.66</b>
Хангамжийн материал	8,291,078.42	9,327,675.66
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,121,727,512.63</b>	<b>33,626,382,376.25</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>277,691,611.03</b>	<b>405,349,790.71</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>276,805,757.07</b>	<b>403,803,007.69</b>
Авто-тээврийн хэрэгсэл	287,700,120.00	395,400,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(123,870,885.00)	(94,666,666.80)
Машин, тоног төхөөрөмж	68,701,270.00	77,044,820.00
Хуримтлагдсан элэгдэл	(36,512,854.98)	(49,987,990.08)
Тавилга, аж ахуйн эд хогшил	107,555,543.00	110,909,943.00
Хуримтлагдсан элэгдэл	(26,767,435.95)	(34,897,098.43)
Дуусаагүй барилга байгууламж		
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>885,853.96</b>	<b>1,546,783.02</b>
Бусад биет бус хөрөнгө	2,407,117.00	4,002,117.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,521,263.04)	(2,455,333.98)
<b>БУСАД ХӨРӨНГӨ</b>		
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>277,691,611.03</b>	<b>405,349,790.71</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,399,419,123.66</b>	<b>34,031,732,166.96</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>Богино хугацаат зээл</b>		
<b>Өглөг</b>	<b>3,527,086,577.50</b>	<b>7,336,416,697.60</b>
Ажиллагсадтай холбогдсон өглөг		628,710.14
Зээлийн хүүгийн өглөг	3,527,086,577.50	6,696,127,304.24
Бусад өглөг		639,660,683.22
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>-</b>	<b>-</b>
Бусад урьдчилж орсон орлого		
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>3,527,086,577.50</b>	<b>7,336,416,697.60</b>
Урт хугацаат зээл	29,572,940,670.98	36,885,501,352.03
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>29,572,940,670.98</b>	<b>36,885,501,352.03</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>33,100,027,248.48</b>	<b>44,221,918,049.63</b>
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(4,700,608,124.82)</b>	<b>(10,190,185,882.67)</b>
Тайлант үеийн үр дүн		(5,489,577,757.85)
Өмнөх үеийн үр дүн		(4,700,608,124.82)
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН</b>	<b>(4,700,608,124.82)</b>	<b>(10,190,185,882.67)</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН</b>	<b>28,399,419,123.66</b>	<b>34,031,732,166.96</b>



Байгууллагын нэр: Таван толгойн цахилгаан станц, төслийн нэгж

Бэлтгэсэн огноо: 2017.01.30

Тайлант хугацаа: 2016.12.31

### АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>Татаас санхүүжилтын орлогын дүн</b>	<b>62,619,141.97</b>	<b>97,900,807.81</b>
Өмчийн орлого	62,499,826.97	97,461,936.45
<b>Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого</b>	<b>119,315.00</b>	<b>438,871.36</b>
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	119,315.00	164,684.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		274,187.36
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>62,619,141.97</b>	<b>97,900,807.81</b>
<b>Бараа ажил үйлчилгээний зардал</b>	<b>1,245,038,451.27</b>	<b>1,158,023,062.69</b>
<b>Ажиллагсадтай холбогдсон зардал</b>	<b>798,536,682.43</b>	<b>676,994,366.54</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>719,235,224.00</b>	<b>609,563,059.98</b>
Цалин	663,017,864.00	574,013,059.98
Урамшуулал	45,817,360.00	22,750,000.00
Гэрээт ажиллагсадын цалин	10,400,000.00	12,800,000.00
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>79,301,458.43</b>	<b>67,431,306.56</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	64,904,794.90	55,166,414.54
Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,495,845.91	42,927,122.42
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,770,954.40	4,905,956.84
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	7,198,332.25	6,132,446.06
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,439,662.34	1,200,889.22
Эрүүл мэндийн даатгалын хураамж	14,396,663.53	12,264,892.02
<b>Тогтмол зардал</b>	<b>117,527,228.78</b>	<b>119,336,059.58</b>
Гэрэл цахилгааны зардал	2,008,748.78	1,810,240.85
Түлш, халаалтын зардал		
Цэвэр, бохир усны зардал		
Байрны түрээс	115,518,480.00	117,525,818.73
<b>Хангамж бараа материалын зардал</b>	<b>59,088,562.98</b>	<b>39,342,837.16</b>
Бичиг хэргийн материал	7,443,910.00	6,411,681.00
Тээвэр, шатахууны зардал	26,068,806.92	14,495,970.12
Шуудан холбооны зардал	10,414,615.06	12,322,810.04
Ном хэвлэлийн зардал	837,430.00	750,000.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	14,323,801.00	4,630,976.00
Бараа материал акталсны зардал		731,400.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,309,700.00</b>	<b>15,016,680.00</b>
Урсгал засварын зардал	2,309,700.00	15,016,680.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>150,158,176.56</b>	<b>131,452,308.00</b>
Гадаад томилолтын зардал	93,356,495.90	75,385,292.00
Дотоод томилолтын зардал	23,989,970.66	34,525,730.00
Гадаад зочны зардал	32,811,710.00	21,541,286.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>20,864,896.42</b>	<b>67,486,308.38</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	5,630,380.00	21,371,200.00
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал		8,000,000.00



	Даатгалын үйлчилгээ	6,310,214.00	5,356,560.00
	Тээврийн хэрэгслийн татвар	787,850.00	326,600.00
	Тээврийн хэрэгслийн оношилгоо	10,000.00	27,500.00
	Мэдээлэл технологийн үйлчилгээ	8,010,000.00	32,282,500.00
	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний	116,452.42	121,948.38
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>96,553,204.10</b>	<b>108,394,503.03</b>
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,720,805.00	61,297,297.82
	Элэгдлийн зардал	79,832,399.10	47,097,205.21
<b>Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн</b>		<b>1,245,038,451.27</b>	<b>1,158,023,062.69</b>
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>		<b>(1,182,419,309.30)</b>	<b>(1,060,122,254.88)</b>
<b>Үйл ажиллагааны бусад орлого</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>
	Гадаад валютын ханшны зөрүүгийн олз /бодит/	1,718,906,256.30	6,094,920,758.24
<b>Үйл ажиллагааны бусад орлогын дүн</b>		<b>1,718,906,256.30</b>	<b>6,094,920,758.24</b>
<b>Үйл ажиллагааны бусад зардал</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>
	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	16,122,779.53	63,537,565.11
	Гадаад валютын ханшны зөрүүг	2,354,571,649.96	10,460,838,696.10
<b>Үйл ажиллагааны бусад зардлын дүн</b>		<b>2,370,694,429.49</b>	<b>10,524,376,261.21</b>
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>		<b>(1,834,207,482.49)</b>	<b>(5,489,577,757.85)</b>



Байгууллагын нэр: Таван толгойн цахилгаан станц, төслийн нэгж

Бэлтгэсэн огноо: 2017.01.30

Тайлант хугацаа: 2016.12.31

### АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>1,353,216,429.37</b>	<b>4,709,663,639.25</b>
Өмчийн орлого	62,499,826.97	97,461,936.45
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		285,884.00
Ханшийн зөрүүний олз	1,290,716,602.40	4,611,915,818.80
Бусад орлого		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,353,216,429.37</b>	<b>4,709,663,639.25</b>
<b>Бараа ажил үйлчилгээний зардал</b>	<b>2,735,651,966.56</b>	<b>1,120,925,307.22</b>
<b>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</b>	<b>797,879,504.43</b>	<b>676,365,656.40</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>718,578,041.83</b>	<b>612,308,458.83</b>
Цалин	688,578,868.83	578,985,458.83
Үр дүнгийн урамшуулал	10,400,000.00	20,523,000.00
Гэрээтийн цалин	19,599,173.00	12,800,000.00
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>79,301,462.60</b>	<b>64,057,197.57</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,499,918.15	40,779,962.09
Тэтгэмж даатгалын шимтгэл	5,771,419.89	4,660,567.09
ҮОМШӨ-ий даатгалын шимтгэл	7,198,913.09	5,825,708.87
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,433,383.23	1,139,541.78
Эрүүл мэндийн даатгалын хураамж	14,397,828.24	11,651,417.74
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,937,772,462.13</b>	<b>444,559,650.82</b>
<b>Тогтмол зардал</b>	<b>117,527,228.78</b>	<b>119,336,059.58</b>
Гэрэл цахилгааны зардал	2,008,748.78	1,810,240.85
Байрны түрээсийн зардал	115,518,480.00	117,525,818.73
<b>Хангамж бараа материалын зардал</b>	<b>60,406,741.85</b>	<b>40,363,045.04</b>
Бичиг хэргийн материал	6,561,180.00	7,771,401.00
Тээвэр, шатахууны зардал	26,117,115.00	14,169,200.00
Шуудан холбооны зардал	10,414,615.06	12,322,810.04
Ном хэвлэлийн зардал	837,430.00	750,000.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	16,476,401.79	5,349,634.00
<b>Эд хогшил урсгал засварын зардал</b>	<b>2,309,700.00</b>	<b>14,335,880.00</b>
Урсгал засварын зардал	2,309,700.00	14,335,880.00
<b>Томилот, зочны зардал</b>	<b>150,241,185.90</b>	<b>131,452,310.00</b>
Гадаад томилолтын зардал	93,356,495.90	75,385,292.00
Дотоод томилолтын зардал	24,072,980.00	34,525,730.00
Гадаад зочны зардал	32,811,710.00	21,541,288.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>1,590,566,800.60</b>	<b>77,775,058.38</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	1,575,332,284.18	28,607,450.00
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал		8,000,000.00
Даатгалын үйлчилгээ	6,310,214.00	5,356,560.00
Тээврийн хэрэгслийн татвар	787,850.00	326,600.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	8,010,000.00	35,335,000.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	10,000.00	27,500.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний	116,452.42	121,948.38



<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,720,805.00</b>	<b>61,297,297.82</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,720,805.00	61,297,297.82
<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>290,964,210.68</b>	<b>767,506,330.85</b>
Ханшийн зөрүү	290,964,210.68	767,506,330.85
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>3,026,616,177.24</b>	<b>1,888,431,638.07</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>(1,673,399,747.87)</b>	<b>2,821,232,001.18</b>
<b>Хөрөнгийн орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Бусад хөрөнгө		
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал		
Хөрөнгийн бусад зардал	33,204,544.00	238,292,950.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)</b>	<b>33,204,544.00</b>	<b>238,292,950.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (VI)=(IV)-(V)</b>	<b>(33,204,544.00)</b>	<b>(238,292,950.00)</b>
<b>САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Авсан зээл		
Төлсөн зээл		
<b>САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)</b>	<b>(1,706,604,291.87)</b>	<b>2,582,939,051.18</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>18,131,513,195.75</b>	<b>16,424,908,903.88</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>16,424,908,903.88</b>	<b>19,007,847,955.06</b>



Байгууллагын нэр: Таван толгойн цахилгаан станц, төслийн нэгж

Бэлтгэсэн огноо: 2017.01.30

Тайлант хугацаа: 2016.12.31

### АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
Аудит хийгдээгүй	<b>2015 оны 12-р сарын 31 -ээрх үлдэгдэл</b>			<b>(4,700,608,124.82)</b>	<b>(4,700,608,124.82)</b>
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(4,700,608,124.82)	(4,700,608,124.82)
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ				-
	Тайлант үеийн үр дүн			(5,489,577,757.85)	(5,489,577,757.85)
	<b>2016 оны 12-р сарын 31 -ээрх үлдэгдэл</b>		-	-	<b>(10,190,185,882.67)</b>
Аудит хийгдсэн	<b>2015 оны 12-р сарын 31 -ээрх үлдэгдэл</b>	-	-	<b>(4,700,608,124.82)</b>	<b>(4,700,608,124.82)</b>
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(4,700,608,124.82)	(4,700,608,124.82)
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	-	-	-	-
	Тайлант үеийн үр дүн	-	-	(5,489,577,757.85)	(5,489,577,757.85)
	<b>2016 оны 12-р сарын 31 -ээрх үлдэгдэл</b>	-	-	<b>(10,190,185,882.67)</b>	<b>(10,190,185,882.67)</b>



Байгууллагын нэр: Таван толгойн цахилгаан станц, төслийн нэгж

Бэлтгэсэн огноо: 2017.01.30

Тайлант хугацаа: 2016.12.31

**Төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Илүү /-/ Дутуу /+/ Хувь	Хувь
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,104,343,598.00</b>	<b>1,359,218,257.22</b>	7,745,125,340.78	14.9
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	9,104,343,598.00	1,359,218,257.22	7,745,125,340.78	14.9
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	8,860,343,598.00	1,120,925,307.22	7,739,418,290.78	12.7
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>1,678,970,560.00</b>	<b>1,120,925,307.22</b>	558,045,252.78	66.8
<b>1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>913,280,000.00</b>	<b>612,308,458.83</b>	300,971,541.17	67.0
Үндсэн цалин	771,900,000.00	578,985,458.83	192,914,541.17	75.0
Үр дүнгийн урамшуулал	54,980,000.00	20,523,000.00	34,457,000.00	37.3
Гэрээтийн цалин	86,400,000.00	12,800,000.00	73,600,000.00	14.8
<b>1.2 Ажил олгогчоос төлөх НДШ</b>	<b>100,393,600.00</b>	<b>64,057,197.57</b>	36,336,402.43	63.8
Тэтгэврийн даатгал	63,886,836.36	40,779,962.09	23,106,874.27	63.8
Тэтгэмжийн даатгал	7,301,352.73	4,660,567.09	2,640,785.64	63.8
ҮОМШӨ даатгал	9,126,690.91	5,825,708.87	3,300,982.04	63.8
Ажилгүйдлийн даатгал	1,825,338.18	1,139,541.78	685,796.40	62.4
Эрүүл мэндийн даатгалын хураамж	18,253,381.82	11,651,417.74	6,601,964.08	63.8
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>122,742,480.00</b>	<b>119,336,059.58</b>	3,406,420.42	97.2
Гэрэл цахилгаан	3,600,000.00	1,810,240.85	1,789,759.15	50.3
Байрны түрээс	119,142,480.00	117,525,818.73	1,616,661.27	98.6
<b>Хангамж бараа материалын зардал</b>	<b>60,886,360.00</b>	<b>40,363,045.04</b>	20,523,314.96	66.3
Бичиг хэрэг	9,348,300.00	7,771,401.00	1,576,899.00	83.1
Тээвэр (шатахуун)	26,938,060.00	14,169,200.00	12,768,860.00	52.6
Шуудан холбоо	13,590,000.00	12,322,810.04	1,267,189.96	90.7
Ном хэвлэл авах	810,000.00	750,000.00	60,000.00	92.6
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	10,200,000.00	5,349,634.00	4,850,366.00	52.4
<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>14,500,000.00</b>	<b>14,335,880.00</b>	164,120.00	98.9
Урсгал засвар	14,500,000.00	14,335,880.00	164,120.00	98.9
<b>Томилолт ,зочны зардал</b>	<b>237,654,480.00</b>	<b>131,452,310.00</b>	106,202,170.00	55.3
Гадаад албан томилолт	138,422,480.00	75,385,292.00	63,037,188.00	54.5
Зочин төлөөлөгч хүлээн авах	54,000,000.00	21,541,288.00	32,458,712.00	39.9
Дотоод албан томилолт	45,232,000.00	34,525,730.00	10,706,270.00	76.3
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ</b>	<b>146,679,640.00</b>	<b>77,775,058.38</b>	68,904,581.62	53.0
Аудит баталгаажуулалт	25,000,000.00	8,000,000.00	17,000,000.00	32.0
Тээврийн хэрэгслийн татвар	609,100.00	326,600.00	282,500.00	53.6
Тээврийн оншилгоо	40,000.00	27,500.00	12,500.00	68.8
Даатгалын үйлчилгээ	14,800,000.00	5,356,560.00	9,443,440.00	36.2
Мэдээлэл технологийн үйлчилгээ	70,000,000.00	35,335,000.00	34,665,000.00	50.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,730,540.00	28,607,450.00	7,123,090.00	80.1
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	121,948.38	378,051.62	24.4
<b>Бараа үйлчилгээний бусад</b>	<b>82,834,000.00</b>	<b>61,297,297.82</b>	21,536,702.18	74.0



<b>зардал</b>				
Хичээл сургалт үйлдвэрлэлийн зардал	82,834,000.00	61,297,297.82	21,536,702.18	74.0
<b>Төсвийн бэлтгэл ажлын зардал</b>	<b>7,181,373,038.00</b>		7,181,373,038.00	-
<b>Хөрөнгийн зардал</b>	<b>244,000,000.00</b>	<b>238,292,950.00</b>	5,707,050.00	97.7
Бусад хөрөнгө	244,000,000.00	238,292,950.00	5,707,050.00	97.7
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>		<b>4,709,663,639.25</b>		
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх		285,884.00		
Бусад орлого		4,709,377,755.25		
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>16,424,908,903.88</b>		
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>19,007,847,955.06</b>		
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
АЖИЛЛАГСАД БҮГД	25	13		
Удирдах ажилтан	5	3		
Гүйцэтгэх ажилтан	18	8		
Үйлчлэх ажилтан	2	2		
Гэтээт ажилтан				